



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

1023. 10.24 № 31-1/146  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Хавсралт – хуудастай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САИД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000234004196



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023. 10. 20 № ХТТ/2379  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт <sup>50</sup> хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА


Д.АМАРБАЯСГАЛАН

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэлд:

**“Х.ХЭЛЭЛЦСЭН нь:** Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.10.07 № 9/5118

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
С.ЧИНЗОРИГ ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

151604825  
Дос.уям а5.2023



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.10.20 № 01/7754  
танай \_\_\_\_\_-ны № 1а/4443 -т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
С.ЧИНЗОРИГ ТАНАА**

Танаас ирүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761002320



## ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

### 1.1 Хууль зүйн үндэслэл

Эрүүл мэндийн тухай хуулийн 13.2 дахь хэсэгт “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна” гэж заасан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь хандив, тусламж, эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон эх үүсвэр, архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь, тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөс бүрдэнэ гэж заасан байдаг.

Мөн тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт тус сангийн хөрөнгийг эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгагдсан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа дараах байдлаар тусгагдсан. Үүнд,

- 2.2.13-д Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ гадаадын иргэд манай оронд ирж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.
- 2.2.28-д Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.

### 1.2 Практик үндэслэл, шаардлага

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт сангийн хөрөнгийг эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг санхүүжүүлэх, энэ чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ гэсэн ерөнхий байдлаар тусгагдсан.

Эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлд Монгол Улсын Засгийн газар эрүүл мэндийн талаар батлагдсан бодлого, хөтөлбөрийг санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих болон зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журам батлах бүрэн эрхтэйг заасан.

Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолоор "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам"-ыг баталсан. Мөн Эрүүл мэндийг дэмжих санд олгох хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт жил бүр тусгаж байхыг Сангийн сайдад, сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайдад тус тус даалгасан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь хандив, тусламж, эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон эх үүсвэр, архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь, тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөс бүрдэнэ гэж заасан байдаг. Энэхүү эх үүсвэрийн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих санд жилд дунджаар 3 орчим тэрбум төгрөгийг Сангийн яамнаас хуваарилдаг.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан татварын орлогоос 2023 онд 10 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийг дэмжих санд хуваарилан олгох боломжтой байгаа хэдий ч 2.7 тэрбум төгрөгийг Сангийн яамнаас Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад хуваарилсан байна.

Монгол Улсын эрүүл мэндийн үзүүлэлтээр хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаанд харьцангуй урьдчилан сэргийлэх боломжтой, хүний эрүүл амьдрах мэдлэг, боловсрол, зан үйлээс шалтгаалсан халдварт бус өвчин давамгайлж нийт өвчлөлийн 80 гаруй хувийг эзэлж байна.

Хүн амын эрүүл амьдралын хэв маягт тухайн хүний зан үйл, мэдлэг боловсролоос гадна нийгэм, эдийн засгийн хүчин зүйл, салбар дундын хамтын ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлт, дэлхий дахинаа асар хурдацтай хөгжиж байгаа шинэ дэвшилтэт техник, технологи ихээхэн нөлөөлж байна.

Дэлхийн улс орнууд Тогтвортой хөгжлийн зорилтод хүрч хүний эрүүл, энх сайн, сайхан байдлыг хангахад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн бүрт тэгш, хүртээмжтэй хүргэх, иргэн оршин буй газраасаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүгийн эрсдэлгүйгээр авах боломжийг бүрдүүлэхийг зорьж байна. Тийм ч учраас Монгол Улсын Засгийн газар 2017 оноос эхлэн гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлсэн иргэдэд эмчилгээний зардлын дэмжлэг үзүүлж эхэлсэн. Энэхүү санхүүжилтэд жил бүр 500,0 сая төгрөг батлагддаг бөгөөд 2023 оны байдлаар нийт 520 иргэн энэхүү санхүүгийн дэмжлэг авсан байна. Тус дэмжлэгийн хүрээнд 1 иргэн 5 хүртлэх сая төгрөгийн дэмжлэг авч байгаа нь иргэдийн зарцуулсан эмчилгээний зардалтай харьцуулахад ихээхэн бага байгаа юм. Тухайлбал, 2019 онд эрхтэн шилжүүлэн суулгахад иргэнээс дунджаар 78 сая төгрөг гарч байсан бол 2023 онд энэ зардал 200-400 сая төгрөг болж өссөн байна.

2022 онд тус дэмжлэгт санхүүжилт авахаар 81 иргэн хандсан хэдий ч батлагдсан санхүүжилт хүрэлцээгүйн улмаас 18 иргэний санхүүжилтийг 2023 оны санхүүжилтээс олгоод байна.

Монгол Улсад 2000 онд Донорын тухай анхдагч хууль, 2018 онд тус хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж өнөөг хүртэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Донорын тухай хуульд 2012-2021 онд нийт 4 удаа нэмэлт, өөрчлөлт орсон.

ДЭМБ-аас эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг аль болох амьгүй донороос хийхийг улс орнуудад зөвлөмж болгож байна. Зөвлөмжийн хүрээнд манай улс нийт 3800 гаруй тархины үхэлтэй донорыг илрүүлж 24 бодит донороос 31 хүнд бөөр, 21 хүнд элэг шилжүүлэн суулгах, 80 гаруй хүнд шөрмөс суулгах мэс заслын эмчилгээг амжилттай хийгээд байна. 2023 оны 10 дугаар сарын байдлаар эрхтэн шилжүүлэн суулгуулах шаардлагатай нийт 826 иргэн байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлэх орлогыг бүрэн татан төвлөрүүлж, Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад хуваарилж олговол өмнө нь дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжиж байсан нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнээс гадна шинээр батлагдсан төсөл, арга хэмжээний төлөвлөгөө ("Элэг бүтэн Монгол", "Эрүүл, идэвхтэй амьдрал", "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" г.м.)-г хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг нэмэгдүүлэх боломжтой юм. Мөн орлогыг бүрэн төвлөрүүлснээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчнийг оношлох, эмчлэх технологи нутагшуулах үйл ажиллагааг санхүүжүүлэх болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангаагүй эсхүл тэтгэмжийн шимтгэл төлж байгаагүй амьгүй донорын эрхийг хүндэтгэж оршуулгын тэтгэмж олгох боломж бүрдэнэ.

Иймд дээр дурдсан асуудлыг хуулиар зохицуулах, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байна.

### **Хоёр. Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэнд эрүүл зан үйл төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа, хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг судлах, тандах үйл ажиллагаа, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний технологийг нутагшуулах үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг нэмэгдүүлэх, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангаагүй эсхүл тэтгэмжийн шимтгэл төлж байгаагүй амьгүй донорт оршуулгын тэтгэмж олгохтой холбоотой хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд оруулах өөрчлөлтийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу боловсруулна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг өөрчлөн найруулж, 19.3 дахь хэсэгт иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэнд эрүүл зан үйл төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх

мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах, хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг судлах, тандах, эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх, нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаагүй, нийгмийн даатгалын тухай хульд заасны дагуу шимтгэл төлөх хугацаа нь хүрэхгүй байгаа амьгүй донорт олгох оршуулгын тэтгэмжийг шийдэх өөрчлөлтийг тус тус оруулна. Мөн өнөөгийн хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хуулиар Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зөвхөн зарцуулах, хяналт тавих журам хэрэгжиж байгааг өөрчилж сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам болгон өөрчлөх асуудлыг хуулийн төсөлд тусгана.

Шаардлагатай бол дээр дурдсан өөрчлөлттэй холбоотой бусад өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгана.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын нийгэм эдийн засагт дараах зэрэг үр дүн гарна.

1. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг бүрэн төвлөрүүлж үйл ажиллагааг өргөжүүлэн дан ганц нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ бус хүний эрүүл мэндэд сөрөөр нөлөөлөх хүчин зүйлээс үүдэлтэй өвчнийг эмчилж эдгэрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах зэрэг арга хэмжээнд зарцуулснаар иргэдэд эрүүл мэндийн улмаас үүсэх санхүүгийн дарамтыг бууруулах, дундаж наслалтыг уртасгах ач холбогдолтой болно.
2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчнийг эмчлэх технологийг нутагшуулах хүний нөөцийн чадавх бэхжинэ.
3. Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчнийг эх орондоо оношилж эмчилдэг болох боломж сайжирна.
4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангаагүй эсхүл тэтгэмжийн шимтгэл төлж байгаагүй амьгүй донорт олгох оршуулгын тэтгэмж олгох асуудал шийдэгдэнэ.

**Дөрөв. Хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох заалт байхгүй.

Хуулийн төсөлтэй холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам" болон Засгийн газрын 2011 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан "Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт орох болно.

---ooOoo---

## ТАНИЛЦУУЛГА

### Хуульд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь хандив, тусламж, эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон эх үүсвэр, архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь, тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөс бүрдэнэ гэж заасан байдаг. Мөн тус хуулийн 19.3 дахь хэсэгт Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажил зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгагдсан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэхтэй холбоотой дараах үйл ажиллагаа тусгагдсан:

- 2.2.13-д Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ гадаадын иргэд манай оронд ирж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.
- 2.2.28-д Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.

Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолоор Эрүүл мэндийг дэмжих санд олгох хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт жил бүр тусгаж байхыг Сангийн сайдад, Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайдад тус тус даалгасан. Үүний дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан эх үүсвэрийн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих санд жилд дунджаар 3 тэрбум төгрөгийг Сангийн яамнаас Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад баталж байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих санд татан төвлөрүүлэх орлогыг бүрэн татан төвлөрүүлж, Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад хуваарилж олговол өмнө нь дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжиж байсан нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнээс гадна шинээр батлагдсан төсөл, арга хэмжээний төлөвлөгөө ("Элэг бүтэн Монгол", "Эрүүл, идэвхтэй амьдрал", "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" г.м.)-г хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг нэмэгдүүлэх боломжтой юм. Мөн орлогыг бүрэн төвлөрүүлснээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчнийг оношлох, эмчлэх технологи нутагшуулах үйл ажиллагааг санхүүжүүлэх болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих

хугацааг хангаагүй эсхүл тэтгэмжийн шимтгэл төлж байгаагүй амьгүй донорын эрхийг хүндэтгэж оршуулгын тэтгэмж олгох боломж бүрдэнэ.

Иймээс хуульд энэхүү үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тусган Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төсөл батлагдсанаар Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх нийгмийн эрүүл мэндийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх, Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний технологи нутагшуулахад хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх тухайлбал, гадаадын өндөр хөгжилтэй орноос төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын баг урьж авчран өөрийн орны эмч нарыг ажлын байранд нь сургах, өөрийн орны эмч нарыг гадаад улс оронд багаар нь сурган чадавхжуулахад шаардагдах санхүүжилт шийдэгдэнэ. Мөн Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалтад орсон өвчний тоо, иргэдийн зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэхэд хувиасаа төлөх төлбөрийн хэмжээ буурч, иргэд эрүүл мэндээсээ үүдэлтэй ядууралд өртөх, санхүүгийн дарамт буурахад эерэгээр нөлөөлнө.

Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлсэн иргэдэд олгох дэмжлэгт 2017-2023 онд жил бүр 500,0 сая төгрөг батлагдаж нийт 520 иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. 2022 онд ЭМЯ-нд 81 иргэн дэмжлэг хүссэн өргөдөл ирүүлсэн хэдий ч тухайн онд иргэдэд олгохоор батлагдсан санхүүжилт дууссан шалтгаанаар 18 иргэнд 2023 оны санхүүжилтээс олгогдсон байна.

Монгол Улсад 2000 онд Донорын тухай анхдагч хууль, 2018 онд тус хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж өнөөг хүртэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Донорын тухай хуульд 2012-2021 онд нийт 4 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ. 2023 оны 10 дугаар сарын байдлаар эрхтэн шилжүүлэн суулгуулах шаардлагатай нийт 826 иргэн байна.

ДЭМБ-аас эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг аль болох амьгүй донороос хийхийг улс орнуудад зөвлөмж болгож байна. Зөвлөмжийн хүрээнд манай улс нийт 3800 гаруй тархины үхэлтэй донорыг илрүүлж 24 бодит донороос 31 хүнд бөөр, 21 хүнд элэг шилжүүлэн суулгах, 80 гаруй хүнд шөрмөс суулгах мэс заслын эмчилгээг амжилттай хийгээд байна.

Хуулийн төсөл, танилцуулгад олон нийтээс санал авахаар Эрүүл мэндийн яамны вэб сайтад 2023 оны 05 дугаар сарын 23-аас 06 дугаар сарын 23-ны хугацаанд байршуулан нээлттэй хэлэлцүүлсэн.

Хуулийн төслийг Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

### Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь хандив, тусламж, эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон эх үүсвэр, архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь, тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөс бүрдэнэ гэж заасан байдаг. Мөн тус хуулийн 19.3 дахь хэсэгт Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгагдсан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэхтэй холбоотой дараах хоёр үйл ажиллагаа тусгагдсан байна:

- 2.2.13-д Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ гадаадын иргэд манай оронд ирж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.
- 2.2.28-д Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.

Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолоор Эрүүл мэндийг дэмжих санд олгох хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт жил бүр тусгаж байхыг Сангийн сайдад, Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайдад тус тус даалгасан. Үүний дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан эх үүсвэрийн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих санд жилд дунджаар 3 тэрбум төгрөгийг Сангийн яамнаас Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад баталж өгдөг. Эрүүл мэндийг дэмжих сангийн 2008-2023 оны хооронд нийт 771 хуулийн этгээдэд 34.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Архи, согтууруулах ундаа, тамхины онцгой албан татвар, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын орлогоос Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан хувиар тооцож үзэхэд 2024 онд 10 тэрбум төгрөгийг эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлэх боломжтой. 2023 онд 2.7 тэрбум төгрөгийг Сангийн яамнаас Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад хуваарилсан.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих санд татан төвлөрүүлэх орлогыг бүрэн татан төвлөрүүлж, Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад хуваарилж олговол өмнө нь дэмжих сангийн

санхүүжилтээр хэрэгжиж байсан нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнээс гадна шинээр батлагдсан төсөл, арга хэмжээний төлөвлөгөө ("Элэг бүтэн Монгол", "Эрүүл, идэвхтэй амьдрал", "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" г.м.)-г хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг нэмэгдүүлэх боломжтой юм. Мөн орлогыг бүрэн төвлөрүүлснээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчнийг оношлох, эмчлэх технологи нутагшуулах үйл ажиллагааг санхүүжүүлэх болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангаагүй эсхүл тэтгэмжийн шимтгэл төлж байгаагүй амьгүй донорын эрхийг хүндэтгэж оршуулгын тэтгэмж олгох боломж бүрдэнэ.

Иймээс хуульд энэхүү үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тусган Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төсөл батлагдсанаар Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх нийгмийн эрүүл мэндийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх, Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний технологи нутагшуулахад хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх тухайлбал, гадаадын өндөр хөгжилтэй орноос төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын баг урьж авчран өөрийн орны эмч нарыг ажлын байранд нь сургах, өөрийн орны эмч нарыг гадаад улс оронд багаар нь сурган чадавхжуулахад шаардагдах санхүүжилт шийдэгдэнэ. Мөн Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалтад орсон өвчний тоо, иргэдийн зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэхэд хувиасаа төлөх төлбөрийн хэмжээ буурч, иргэд эрүүл мэндээсээ үүдэлтэй ядууралд өртөх, санхүүгийн дарамт буурахад эерэгээр нөлөөлнө.

Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлсэн иргэдэд олгох дэмжлэгт 2017-2023 онд жил бүр 500,0 сая төгрөг батлагдаж нийт 520 иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. 2022 онд ЭМЯ-нд 81 иргэн дэмжлэг хүссэн өргөдөл ирүүлсэн хэдий ч тухайн онд иргэдэд олгохоор батлагдсан санхүүжилт дууссан шалтгаанаар 18 иргэнд 2023 оны санхүүжилтээс олгогдсон байна.

Монгол Улсад 2000 онд Донорын тухай анхдагч хууль, 2018 онд тус хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж өнөөг хүртэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Донорын тухай хуульд 2012-2021 онд нийт 4 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ. 2023 оны 10 дугаар сарын байдлаар эрхтэн шилжүүлэн суулгуулах шаардлагатай нийт 826 иргэн байна.

ДЭМБ-аас эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг аль болох амьгүй донороос хийхийг улс орнуудад зөвлөмж болгож байна. Зөвлөмжийн хүрээнд манай улс нийт 3800 гаруй тархины үхэлтэй донорыг илрүүлж 24 бодит донороос 31 хүнд бөөр, 21 хүнд элэг шилжүүлэн суулгах, 80 гаруй хүнд шөрмөс суулгах мэс заслын эмчилгээг амжилттай хийгээд байна.

Хуулийн төсөл, танилцуулгад олон нийтээс санал авахаар Эрүүл мэндийн яамны вэб сайтад 2023 оны 05 дугаар сарын 23-аас 06 дугаар сарын 23-ны хугацаанд байршуулан нээлттэй хэлэлцүүлсэн.

Хуулийн төслийг Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэх явцад тухайн үед үүссэн онцгой нөхцөл байдалтай холбоотойгоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангахгүй эсхүл тэтгэмжийн шимтгэл төлж байгаагүй амьгүй донорт олгох оршуулгын тэтгэмж олгох асуудал болон Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулах, хяналт тавихтай холбогдсон журмыг Засгийн газар батлах заалт тус тус дэмжигдсэн.

Хуулийн зүйл, заалтад оруулах өөрчлөлтийн тайлбар:

д/д	Одоо хүчин төгөлдөр хуулийн заалт	Нэмэлт өөрчлөлт оруулсан төсөл	Тайлбар
1	19 дүгээр зүйлийн 19.1.Эрүүл мэндийг дэмжих сан нь эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай байна.	19 дүгээр зүйлийн 19.1. Эрүүл мэндийг дэмжих сан нь хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зориулалттай байна.	Өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх асуудлыг нэмж найруулсан.
2	19 дүгээр зүйлийн 19.3. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг дараах чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна: 19.3.1.халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх; 19.3.2.халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх; 19.3.3.орчны эрүүл мэндийг хамгаалах; 19.3.4.осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх; 19.3.5.сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх;	19 дүгээр зүйлийн 19.3.Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:  19.3.1. иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэнд эрүүл зан үйл төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа;  19.3.2.хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг судлах, тандах үйл ажиллагаа;  19.3.3.эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах;  19.3.4.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи	Хуулийн 7 заалтыг багцалж 6 болгон тодорхойлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, зарим амьгүй донорт оршуулгын тэтгэмж олгох асуудлыг тусгасан. .  Монгол Улсын хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтээс дүгнэхэд өвчлөл, нас баралтын шалтгаанд урьдчилан сэргийлэх боломжтой, хүний эрүүл мэндийн мэдлэг боловсрол, зан үйл, ажиллаж, амьдрах хэв маягаас шалтгаалсан халдварт бус өвчин нийт өвчлөлийн 80 гаруй хувийг эзэлж, тасралтгүй нэмэгдсээр байна. Иймд иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх,

	<p>19.3.6.эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах;</p> <p>19.3.7.эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх.</p>	<p>шинээр нэвтрүүлэх үйл ажиллагаа;</p> <p>19.3.5. зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх;</p> <p>19.3.6 Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангахгүй эсхүл тэтгэмжийн шимтгэл төлж байгаагүй амьгүй донорт олгох оршуулгын тэтгэмж.</p>	<p>иргэнд эрүүл зан үйл төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг хуулийн заалт болгон оруулсан.</p> <p>Хуулийн төслийг Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэх явцад тухайн үед үүссэн онцгой нөхцөл байдалтай холбоотойгоор уг заалтыг хэлэлцэж дэмжигдсэн.</p>
3	<p>19 дүгээр зүйлийн 19.5. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журмыг Засгийн газар батална.</p>	<p>19.5 дахь хэсэгт Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журмыг Засгийн газар батална.</p>	<p>Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийг зөвхөн зарцуулах, хяналт тавих журамд Эрүүл мэнийн дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах гэсэн өөрчлөлт оруулсан.</p>

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

19.1. Эрүүл мэндийг дэмжих сан нь хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх болон амьгүй донорт оршуулгын тэтгэмж олгох зориулалттай байна.

19.3. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

19.3.1. иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэнд эрүүл зан үйл төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа;

19.3.2. хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг судлах, тандах үйл ажиллагаа;

19.3.3. эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах;

19.3.4. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх үйл ажиллагаа;

19.3.5. зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх;

19.3.6. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангаагүй эсхүл тэтгэмжийн шимтгэл төлж байгаагүй амьгүй донорт олгох оршуулгын тэтгэмж.

**2 дугаар зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийн “зарцуулах” гэснийг “төвлөрүүлэн зарцуулах” гэж өөрчилсүгэй

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



**ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ**

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот  
2023 он**

## **ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

**Гарчиг**

**Нэг. Ерөнхий зүйл**

**Хоёр. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал**

**Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал**

**Дөрөв. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал**

4.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

4.2. "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

4.4. "Харилцан уялдааг шалгах" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

**Тав. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал**

5.1. Зөвлөмж

5.2. Дүгнэлт

5.3. Баримтжуулалт

## ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН

### Нэг. Ерөнхий зүйл

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн төслийг Эрүүл мэндийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан эсэхийг нягталж, хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ямар үр дагавар, үр нөлөө үзүүлэхийг тооцох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, салбарын бусад хууль тогтоомжийн харилцан уялдааг тогтоох, хуулийн төслийг ойлгомжтой, хүлээн зөвшөөрөгдөх, практикт хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу үр нөлөөний үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13.1.6 дэх хэсэгт заасныг баримтлан Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийх аргачлал”-д нийцүүлэн “хуульд өөрчлөлт оруулах төсөл “хувилбар”-ыг сонгон авч боловсруулсан байна.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг дараах үе шаттайгаар зохион байгуулав:

- шалгуур үзүүлэлтийг сонгох;
- хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох;
- шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

### **Хоёр. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасны дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонгосон:

- зорилгод хүрэх байдал;
- ойлгомжтой байдал;
- харилцан уялдаа.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тул “зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийг сонгон авч, дараах 3 шалгах хэрэгслээр тодорхойлж үзэв:

1. Хуулийн төсөлд туссан зүйлүүд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэж чадах эсэх;
2. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх;
3. Хуулийн төслөөр дэвшүүлсэн зорилгод хүрч чадах эсэх.

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн тухайд дараах 3 шалгах хэрэгслээр тодорхойлов:

1. Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъект буюу иргэн, эрүүл мэндийн ажилтан, албан хаагч, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоод бусад байгууллага, аж ахуйн нэгжийн хувьд ойлгомжтой эсэх;
2. Хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай эсэх;
3. Агуулга, хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой, тодорхой эсэх.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн тухайд хуулийн үр дагаварт шууд хамаарах субъект (эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн чиглэлээр сургалт, сурталчилгаа, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, олон нийтийн үүсгэл санаачилгын байгууллага, аж ахуйн нэгж, иргэд) уг хуулийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэх зорилгоор сонголоо.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хувьд хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой нийцэж байгаа эсхүл зөрчилдөж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх шаардлагатай гэж үзэн тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

#### Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо (Хүснэгт 1).

Хүснэгт 1

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах	Хуулийн төсөлд дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдож чадсан эсэх болон хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгах

2.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах	"Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ын 2 дугаар бүлэгт заасан хуулийн төсөл боловсруулахад тавигдах нийтлэг шаардлага болон 3 дугаар бүлэгт нийцсэн эсэхийг шалгах
3.	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах	"Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын 4.10-т заасан хуулийн төслийн уялдаа холбоог шалгах хэрэгслийн хүрээнд тавигдах шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгах

**Дөрөв. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал**

Энэ тайлангийн 3 дугаар бүлэгт сонгосон хэсгүүдэд шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах байдлаар үнэлгээ хийлээ:

**4.1. "Зорилгод хүрэх байдлыг судлах" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт зааснаар эрүүл мэндийг дэмжих сан нь эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай сан бөгөөд 2006 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь, тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр бүрдүүлэхээр анх байгуулагдсан. Сүүлийн 5 жилийн батлагдсан төсвөөс дүгнэхэд нийгмийн эрүүл мэндийн олон салбарын оролцоотой хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээг дэмжиж ажиллахад маш бага санхүүжилт юм.

2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр татан буугдаж 2 жил завсарлаад 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 2017 оны 01 дүгээр сарын 1-ээс эхлэхээр эргэж сэргээсэн.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасан дараах 7 чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхэд сангийн мөнгийг зарцуулдаг.

1. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх
2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
3. Орчны эрүүл мэндийг хамгаалах
4. Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх
5. Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх

6. Эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах
7. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх

2008-2022 онд нийт 1286 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг шалгаруулж санхүүжилтийг олгон хэрэгжүүлсэн. Дээрхи 7 чиглэлээр ирсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санал, тэдгээрээс сонгон шалгаруулж хэрэгжүүлсэн төслийн сүүлийн 3 жилийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн нийт саналын 42,3 хувь нь халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, 11 хувь нь халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, 4 хувь нь орчны эрүүл мэндийг хамгаалах, 7 хувь нь осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх, 17 хувь нь сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх, 8 хувь нь эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах, 11 хувь нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр ирсэн байна.

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хувьд 36,6 хувь нь сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх, 33,3 хувь нь осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх, 30,6 хувь нь халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, 26,3 хувь нь орчны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хэрэгжсэн байна. Үүнээс харахад Засгийн газрын тусгай санд төвлөрсөн санхүүжилтийг бүрэн хуваарилдаггүй, Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд нь нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламжтай холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дорвитой нэмэр болохгүй байна.

Хүснэгт 2

Д/д	Шалгуур үзүүлэлт, шалгах хэрэгсэл	Хуулийн төсөлд тусгасан зохицуулалт, арга хэмжээ	Төслийн зүйл, заалт
1.	Зорилгод хүрэх байдал Хуулийн төсөлд туссан зүйл, заалтууд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэж чадах эсэх	<ul style="list-style-type: none"> <li>➢ иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэнд эрүүл зан үйл төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа;</li> <li>➢ хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг судлах, тандах үйл ажиллагаа;</li> <li>➢ эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах;</li> <li>➢ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх үйл ажиллагаа;</li> <li>➢ зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх.</li> </ul>	Хуулийн төслийн заалт
2.	Хуулийн төсөл боловсруулах	<ul style="list-style-type: none"> <li>➢ Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн хүрээнд Эрүүл мэндийг</li> </ul>	Хуулийн төслийн заалт

	үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх	<p>дэмжих санд төвлөрүүлэх орлогыг бүрэн татан төвлөрүүлэх,</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр хийгдэж байсан арга хэмжээнээс гадна шинээр батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх,</li> <li>➤ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх,</li> <li>➤ Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх,</li> <li>➤ Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэнд эрүүл зан үйл төлөвшүүлэх,</li> <li>➤ Өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа, хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг судлах, тандах,</li> </ul>	
3.	Хуулийн төслөөр дэвшүүлсэн зорилгод хүрч чадах эсэх	<ul style="list-style-type: none"> <li>➤ Хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийн судалгааг Монгол Улс 5 жил тутам хийдэг ч тогтмол санхүүжилтгүйгээс ДЭМБ, олон улсын байгууллагын санхүүжилт, дэмжлэгээр зохион байгуулдаг. Иймд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан эх үүсвэрийн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтийг нэмэгдүүлэх;</li> <li>➤ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасан дараах 7 чиглэлийг нэгтгэн хуулийн өөрчлөлтийн төсөлд тусгаснаар 5 чиглэл болгон багцалж томъёолох;</li> <li>➤ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчнийг Монгол Улсад эмчлэх технологийг нутагшуулах агуулга бүхий нэмэлт өөрчлөлтийг оруулж томъёолох.</li> </ul>	Хуулийн төслийн заалт

Хуулийн төслөөр дэвшүүлсэн зорилгод хүрч чадах эсэхийг шалгах хэрэгслийг дараах байдлаар үнэлэв (Хүснэгт 3):

Д/д	Хуулийн төслийн зорилт	Хуулийн төслийн зүйл, заалт
1.	Эрүүл мэндийг дэмжих сан нь хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх зориулалттай байна.	Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна: - иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэнд эрүүл зан үйл төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа; - хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг судлах, тандах үйл ажиллагаа; - эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах; - эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх үйл ажиллагаа; - зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх.

Хуулийн төслийн үзэл баримтлалд туссан зорилгод тулгуурлан боловсруулсан хуулийн төслийн зохицуулалт бүрт дүн шинжилгээ хийхэд тухайн зохицуулалт, арга хэмжээ нь зорилгод хүрэх боломжтой гэж дүгнэлээ.

#### 4.2. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын Хоёрдугаар бүлэг “Хуулийн төсөл боловсруулахад тавигдах нийтлэг шаардлага”-т заасан шаардлагыг дараах байдлаар үнэлэв (Хүснэгт 4).

Хуулийн төслийн эх бичвэрийн асуулгад тавигдах шаардлага		
1.	Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Шаардлагыг хангасан.
2.	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх	Шаардлагыг хангасан.
3.	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх	Шаардлагыг хангасан.
4.	Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Шаардлагыг хангасан.
5.	Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх	Хуулийн зүйл, хэсэг заалт бүрийн эрх зүйн үр дагаврыг тодорхойлсон.

<b>Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах шаардлага</b>		
6.	Хуулийн төслийн үг хэллэг, өгүүлбэрийг хэл зүй, найруулга, өгүүлбэр зүйн монгол хэл, бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй, товч тодорхой, ойлгоход хялбар байх	Шаардлагыг хангасан.
7.	Бичвэр нь үндсэн агуулгаас хоёрдогч ач холбогдол бүхий ерөнхийгөөс тусгай руу, нийтлэг журмаас тусгай руу гэсэн хэлбэртэй байх	Шаардлагыг хангасан.
<b>Хуулийн төслийн эх бичвэрт хэрэглэх арга, аргачлал</b>		
8.	1.Нэр томъёо хэрэглэх 2.Хуулийн төслийн үг хэллэг сонгох	Шаардлага хангасан.
<b>Хуулийн төслийн эх бичвэрийг боловсруулахад тавигдах шаардлага</b>		
9.	Хуулийн төслийн эх бичвэрийг боловсруулахад холбогдох эрх зүйн баримт бичгийг баримталсан эсэх	Хуулийн төслийг боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал", Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ыг тус тус баримталсан байна.

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр, 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгасан болно (Хүснэгт 5).

Хүснэгт 5

<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр</b>	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
28.1.Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна: 28.1.1.хуулийн төслийн гарчиг; 28.1.2.хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл; 28.1.3.зүйлийн доторх хэсэг; 28.1.4.хэсгийн доторх заалт; 28.1.5.заалтын доторх дэд заалт;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дугаар зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулга</b>	

Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Хуулийн төслийн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг судлах, тандах, эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэхэд зарцуулахаар тусгасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Хуулийн зүйл, хэсэг заалт бүрийн эрх зүйн үр дагаврыг тодорхойлсон.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төсөл байхгүй.

<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага</b>	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

#### **4.3. “Харилцан уялдааг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

“Харилцан уялдааг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн уялдаа холбоо хангагдсан эсэхийг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-т заасан 16 асуулт тус бүрд хариулах замаар шалган тогтоолоо (Хүснэгт 6).

*Хүснэгт 6*

<b>Д/д</b>	<b>Аргачлалд заасан асуулт</b>	<b>Хуулийн төслийг үнэлсэн байдал</b>
1.	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн зорилго хэсэгт тодорхой туссан.
2.	Хуулийн төслийн “хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.3 дахь хэсгийг өөрчилж байгаа.
3.	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Шаардлага хангасан.
4.	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Бусад хуулийн заалттай нийцэж байна.
5.	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
6.	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажил нь тодорхой болсон.
7.	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

8.	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулаагүй.
9.	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод төсөл хэрэгжүүлж санхүүжилт авах боломж бүрдүүлнэ.
10.	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд татвар болон бусад төрлийн төлбөр, хураамж тогтоосон зохицуулалт тусгагдаагүй байна.
11.	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт байхгүй.
12.	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Хуулийн төсөлд Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй байна.
13.	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төсөлд хүйсийн ялгавартай байдал бий болгосон зүйл, заалт тусгагдаагүй байна.
14.	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байна.
15.	Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тогтоогдоогүй болно.
16.	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хуулийн төсөлд хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тусгагдаагүй.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилоо.

Үүнд Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Дархлаажуулалтын тухай хууль болон холбогдох бусад хууль, хууль тогтоомжийн актад нийцсэн эсэхийг шалгалаа.

#### **Тав. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал**

Хуулийн төсөлд дэвшүүлсэн зорилтийн хүрээнд хамаарах зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг үнэлсэн. Тухайлбал, Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг

иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг судлах, тандах, эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэхэд зарцуулахаар тусгасан нь хуулийн зорилтод нийцэж байна.

Төслийн ойлгомжтой байдлыг хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэх, Хууль тогтоомжийн тухай хууль болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгасан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр, 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг дүгнэхэд энэ төрлийн зөрчил тогтоогдоогүй болно.

### **5.1. Зөвлөмж**

Энэхүү хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын явцад гарсан дараах асуудлыг анхаарч, хуулийн төслийг цаашид боловсронгуй болгох, чанарыг сайжруулах чиглэлээр дараах зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна:

1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан эх үүсвэрийн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтийг бүрэн хуваарилахгүй байгаа тул Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр 19.5 дахь заалтын "хөрөнгийг" гэсний дараа "төвлөрүүлэх," гэж нэмэх,
2. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасан ерөнхий 7 чиглэлийг нэгтгэн хуулийн төсөлд 6 чиглэл болгон оновчтой тусгасныг хэрэгжүүлэх;
3. Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчнийг эмчлэх технологийг нутагшуулах, зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх талаар иргэдээс ирүүлсэн хүсэлтийг бүрэн шийдвэрлэдэг болох,
4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангаагүй эсхүл тэтгэмжийн шимтгэл төлж байгаагүй амьгүй донорт олгох оршуулгын тэтгэмж олгох асуудлыг шийдвэрлэдэг болох.

### **5.2. Дүгнэлт**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг сонгосон дээрх 3 үзүүлэлтээр үнэлэхэд хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зохицуулах харилцаа, хамрах хүрээг хангасан байна. Энэхүү хууль нь хэрэгжих боломжтой, хуулийн төслийн томъёолол

ойлгомжтой, хоёрдмол утга санаа агуулаагүй, бусад хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалт нь давхардаагүй, зөрчилдөөгүй гэж дүгнэж байна.

### **5.3. Баримтжуулалт**

#### **Монгол Улсын хууль:**

1. Монгол Улсын Үндсэн хууль /1992/
2. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль /1993/
3. Эрүүл мэндийн тухай хууль /2011/
4. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /2015/
5. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль /2016/

#### **Засгийн газрын тогтоол:**

1. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал 2016 оны 59 дүгээр тогтоол

--- о0о ---



**ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ**

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН  
СУДАЛСАН ТУХАЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
2023 ОН**

## **АГУУЛГА**

### **Ерөнхий мэдээлэл**

**Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал**

- 1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээ
- 1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд
- 1.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

**Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал**

**Гурав. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн эерэг болон сөрөг талын харьцуулсан байдал**

**Дөрөв. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал**

**Тав. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт**

**Зургаа. тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа**

**Долоо. зөвлөмж**

## **ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТУХАЙ ТАЙЛАН**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа хийв.

### **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Эрүүл мэндийн тухай хуулийн 13.2 дахь хэсэгт “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна” гэж заасан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь хандив, тусламж, эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон эх үүсвэр, архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь, тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөс бүрдэнэ гэж заасан байдаг. Мөн тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт тус сангийн хөрөнгийг эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгагдсан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэхтэй холбоотой хоёр үйл ажиллагаа тусгагдсан байна. Үүнд,

- 2.2.13-д Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ гадаадын иргэд манай оронд ирж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.
- 2.2.28-д Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.

Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолоор Эрүүл мэндийг дэмжих санд олгох хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт жил бүр тусгаж байхыг Сангийн сайдад, Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайдад тус тус даалгасан. Үүний дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан эх үүсвэрийн хүрээнд Эрүүл

мэндийг дэмжих санд жилд дунджаар 3 тэрбум төгрөгийг Сангийн яамнаас Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад баталж өгдөг.

Архи, согтууруулах ундаа, тамхины онцгой албан татвар, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын орлогоос Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан хувиар тооцож үзэхэд 2023 онд 10 тэрбум төгрөгийг эрүүл мэндийг дэмжих санд гүйцэтгэлээр хуваарилан олгох боломжтой ч 2.7 тэрбум төгрөгийг Сангийн яамнаас Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад хуваарилсан.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих санд татан төвлөрүүлэх орлогыг бүрэн татан төвлөрүүлж, Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад хуваарилж олговол өмнө нь дэмжих сангийн санхүүжилтээр хийгдэж байсан арга хэмжээнүүдээс гадна шинээр батлагдсан төсөл, арга хэмжээнүүдийн төлөвлөгөө ("Элэг бүтэн Монгол", "Эрүүл, идэвхтэй амьдрал", "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" г.м.)-г хэрэгжүүлэх санхүүжилтийг шийдвэрлэнэ. Мөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчнийг Монгол Улсад эмчлэх технологийг нутагшуулахад хүний нөөцийг чадавхжуулах, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээ төлөх хугацааг хангаагүй эсхүл нийгмийн даатгалын шимтгэл огт төлж байгаагүй амьгүй донорт олгох оршуулгын тэтгэмж олгох боломжтой болох юм.

Мөн тус хуульд заасан Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зөвхөн зарцуулах, хяналт тавих бус сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам болгон өөрчилнө.

## **НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ**

### **1.4. Асуудлын мөн чанар, цар хүрээ**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт зааснаар эрүүл мэндийг дэмжих сан нь эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай сан бөгөөд 2006 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь, тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр бүрдүүлэхээр анх байгуулагдсан. Сүүлийн 5 жилийн батлагдсан төсвөөс дүгнэхэд нийгмийн эрүүл мэндийн олон салбарын оролцоотой хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээг дэмжиж ажиллахад маш бага санхүүжилт юм.

2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр татан буугдаж 2 жил завсарлаад 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 2017 оны 01 дүгээр сарын 1-ээс эхлэхээр эргэж сэргээсэн.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасан дараах 7 чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхэд сангийн мөнгийг зарцуулдаг.

1. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх
2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
3. Орчны эрүүл мэндийг хамгаалах
4. Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх
5. Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх
6. Эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах
7. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх

Дээрхи ерөнхий 7 заалтыг багцалж тодорхой болгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчнийг Монгол Улсад эмчлэх технологийг нутагшуулах үйл ажиллагааны чиглэлийг нэмэх шаардлагатай байна.

### **1.2.Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хуулийн этгээдэд заавал биелүүлэх шинжтэй үүрэг хариуцлага тусгаагүй тул нэмэгдэл зардал үүсч эрх ашиг нь зөрчигдөхгүй.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд иргэнд үүрэг хүлээлгэсэн зохицуулалт тусгагдаагүй тул иргэнд үүсэх зардал байхгүй, эрх ашиг нь зөрчигдөхгүй.

Аж ахуйн нэгжүүдэд хуулийн хүрээнд төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх боломж нь ил тод, нээлттэй байх тул эрх нь зөрчигдөхгүй.

### **1.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт сангийн хөрөнгийг эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг санхүүжүүлэх, энэ чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ ерөнхий байдлаар тусгагдсан.

Эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлд Монгол Улсын Засгийн газар эрүүл мэндийн талаар батлагдсан бодлого, хөтөлбөрийг санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих болон зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журмыг батлах бүрэн эрхтэйг заасан.

Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолоор "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам"-ыг баталсан. Мөн Эрүүл мэндийг дэмжих санд олгох хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт жил бүр тусгаж байхыг Сангийн сайдад, сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайдад тус тус даалгасан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь хандив, тусламж, эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон эх үүсвэр, архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын

гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь, тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөс бүрдэнэ гэж заасан байдаг. Энэхүү эх үүсвэрийн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих санд жилд дунджаар 3 орчим тэрбум төгрөгийг Сангийн яамнаас хуваарилж өгдөг.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан дээр дурдсан татварын орлогоос 2023 онд 10 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийг дэмжих санд гүйцэтгэлээр хуваарилан олгох боломжтой байгаа хэдий ч 2.7 тэрбум төгрөгийг Сангийн яамнаас Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад хуваарилсан байна.

Монгол Улсын эрүүл мэндийн үзүүлэлтээр хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаанд харьцангуй урьдчилан сэргийлэх боломжтой, хүний эрүүл амьдрах мэдлэг, боловсрол, зан үйлээс шалтгаалсан халдварт бус өвчин давамгайлж нийт өвчлөлийн 80 гаруй хувийг эзэлж байна.

Хүн амын эрүүл амьдралын хэв маягт тухайн хүний зан үйл, мэдлэг боловсролоос гадна нийгэм, эдийн засгийн хүчин зүйл, салбар дундын хамтын ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлт, дэлхий дахинаа асар хурдацтай хөгжиж байгаа шинэ дэвшилтэт техник, технологи ихээхэн нөлөөлж байна.

Дэлхийн улс орнууд Тогтвортой хөгжлийн зорилтод хүрч хүний эрүүл, энх сайн, сайхан байдлыг хангахад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн бүрт тэгш, хүртээмжтэй хүргэх, иргэн оршин буй газраасаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүгийн эрсдэлгүйгээр авах боломжийг бүрдүүлэхийг зорьж байна. Тийм ч учраас Монгол Улсын Засгийн газар 2017 оноос эхлэн гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлсэн иргэдэд эмчилгээний зардлын дэмжлэг үзүүлж эхэлсэн. Энэхүү санхүүжилтэд жил бүр 500,0 сая төгрөг батлагддаг бөгөөд 2023 оны байдлаар нийт 520 иргэн энэхүү санхүүгийн дэмжлэг авсан байна. Тус дэмжлэгийн хүрээнд 1 иргэн 5 хүртлэх сая төгрөгийн дэмжлэг авч байгаа нь иргэдийн зарцуулсан эмчилгээний зардалтай харьцуулахад ихээхэн бага байгаа юм. Тухайлбал, 2019 онд эрхтэн шилжүүлэн суулгахад иргэнээс дунджаар 78 сая төгрөг гарч байсан бол 2023 онд энэ зардал 200-400 сая төгрөг болж өссөн байна.

2022 онд тус дэмжлэгт санхүүжилт авахаар 81 иргэн хандсан хэдий ч батлагдсан санхүүжилт хүрэлцээгүйн улмаас 18 иргэний санхүүжилтийг 2023 оны санхүүжилтээс олгоод байна.

Монгол Улсад 2000 онд Донорын тухай анхдагч хууль, 2018 онд тус хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж өнөөг хүртэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Донорын тухай хуульд 2012-2021 онд нийт 4 удаа нэмэлт, өөрчлөлт орсон.

ДЭМБ-аас эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг аль болох амьгүй донороос хийхийг улс орнуудад зөвлөмж болгож байна. Зөвлөмжийн хүрээнд манай улс нийт 3800 гаруй тархины үхэлтэй донорыг илрүүлж 24 бодит донороос 31 хүнд бөөр, 21 хүнд элэг шилжүүлэн суулгах, 80 гаруй хүнд шөрмөс суулгах мэс заслын эмчилгээг амжилттай хийгээд байна. 2023 оны 10 дугаар сарын байдлаар эрхтэн шилжүүлэн суулгуулах шаардлагатай нийт 826 иргэн байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлэх орлогыг бүрэн татан төвлөрүүлж, Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад хуваарилж олговол өмнө нь дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжиж байсан нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнээс гадна шинээр батлагдсан төсөл, арга хэмжээний төлөвлөгөө ("Элэг бүтэн Монгол", "Эрүүл, идэвхтэй амьдрал", "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" г.м.)-г хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг нэмэгдүүлэх боломжтой юм.

Мөн орлогыг бүрэн төвлөрүүлснээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчнийг оношлох, эмчлэх технологи нутагшуулах үйл ажиллагааг санхүүжүүлэх болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангаагүй эсхүл тэтгэмжийн шимтгэл төлж байгаагүй амьгүй донорын эрхийг хүндэтгэж оршуулгын тэтгэмж олгох боломж бүрдэнэ.

Иймд дээр дурдсан асуудлыг хуулиар зохицуулах, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байна.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын нийгэм эдийн засагт дараах эерэг үр дүн гарна.

1. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг бүрэн төвлөрүүлж үйл ажиллагааг өргөжүүлэн дан ганц нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ бус хүний эрүүл мэндэд сөрөөр нөлөөлөх хүчин зүйлээс үүдэлтэй өвчнийг эмчилж эдгэрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах зэрэг арга хэмжээнд зарцуулснаар иргэдэд эрүүл мэндийн улмаас үүсэх санхүүгийн дарамтыг бууруулах, дундаж наслалтыг уртасгах ач холбогдолтой болно.
2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчнийг эмчлэх технологийг нутагшуулах хүний нөөцийн чадавх бэхжинэ.
3. Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчнийг эх орондоо оношилж эмчилдэг болох боломж сайжирна.
4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангаагүй эсхүл тэтгэмжийн шимтгэл төлж байгаагүй

### **ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Тус хуулийн төслийн үндсэн зорилго нь Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний чиглэлийг багцалж цөөн болгох (7 чиглэлийг 4 болгох), өмнө нь дэмжих сангийн санхүүжилтээр хийгдэж байсан арга хэмжээнүүдээс гадна эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчнийг Монгол Улсад эмчлэх технологийг нутагшуулах үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг нэмэгдүүлэхтэй холбоотой зарим зохицуулалтыг боловсронгуй болгох зорилготой.

Асуудлыг дараах аргачлалын дагуу зохицуулах боломжтой гэж үзлээ.

- Шинээр зохицуулалт хийхгүйгээр асуудлыг шийдвэрлэх
- Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх
- Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх
- Төрийн бус байгууллагаар төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх
- Захиргааны шийдвэр гаргах
- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах

## ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫН ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Хуулийн төсөл боловсруулах аргачлалын тавдугаарт заасны дагуу асуудлыг зохицуулах хувилбаруудыг тодорхойлсноор хоёрдугаар хэсэгт заасан зоригодоо хүрч чадах эсэх, дээрхи зорилтыг биелүүлснээр зардлын хувьд эерэг үр дүн байгаа эсэхийг харгалзан дараах аргуудыг хэрэгжүүлэхэд гаргах зардал, өгөөжийг харьцуулан доорх дүгнэлтийг гаргалаа.

Зохицуулалтын хувилбар	Харьцуулалт		Үр дүн
	зерэг	сөрөг	
1. "тэг" хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Тулгамдаж буй асуудлууд хэвээр байх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй байна.	Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагааны чиглэл хэт ерөнхий, олон чиглэлтэй, тэдгээрт зарцуулагдах санхүүжилт олон хуваагдсан хэвээр байна.	сөрөг
2. Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Тавьсан зорилгодоо хүрэх боломжгүй байна.	Тодорхой хэмжээний зардал гарах боловч асуудлын шалтгааныг арилгахгүй.	сөрөг
3. Зах зээлийн механизм хэрэглэх, төрөөс зохицуулалт хийх	Зорилгодоо хүрэх боломжгүй	Төрийн зохицуулалт зайлшгүй гшаардлагатай тул асуудлыг шийдвэрлэх боломжгүй	сөрөг
4. Захиргааны шийдвэр гаргах	Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийн эх үүсвэр, зарцуулах чиглэлийг хуулиар тогтоосон тул захираганы шийдвэр гаргах боломжгүй	Ямар нэгэн үр өгөөж гарахгүй	сөрөг
5. Төрийн бус байгууллагаар төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Тусгай сангийн тухай хуульд заасан 7 чиглэлээр төрийн бус байгууллагууд төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх боломжтой ч зорилгодоо хүрэхэд хангалтгүй юм.	Хэрэгжих боломжгүй	сөрөг
6. Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар бий болгох тул зорилгодоо хүрэхэд тохиромжтой.	Ямар нэгэн зардал гарахгүйгээр асуудлыг шийдвэрлэх гол арга зам болно.	зерэг

Зорилгодоо хүрэх боломжит байдал, асуудлын эерэг, сөрөг талуудыг үнэлсний үр дүнд Засгийн газрын тусгай сангийн тухай хууль нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах нь асуудлыг шийдвэрлэх арга зам гэж дүгнэн цаашдын судалгааг хийлээ.

**ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН  
СУДАЛСАН БАЙДАЛ**

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх		Үгүй	сөрөг нөлөө байхгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	2.Хүний эрхийг	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	
2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх			Үгүй	
3.Эрх агуулагч[8]	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх		Үгүй	
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх		Үгүй	

	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)		Үгүй	
4.Үүрэг хүлээгч[9]	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		
5.Жендэрийн	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		

Хүснэгт 2

### ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө		Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм		сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм		
	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	
	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм		сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	

4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм		
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм		
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм		
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	хамааралгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх			
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх			
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх			
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх			
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх			
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх			
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	тийм		

## НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр		Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	тийм	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	тийм	зэрэг нөлөө үзүүлнэ

	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	тийм		зэрэг нөлөө үзүүлнэ
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх		Үгүй	
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		үгүй	

Хүснэгт 4

## БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр		Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх		үгүй	

	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		үгүй	
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх			хамааралгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх			хамааралгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх			хамааралгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх			хамааралгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		үгүй	
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		үгүй	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		үгүй	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх		үгүй	
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		үгүй	

### ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Арга	Зорилгодоо хүрэх байдал	Зардал, өгөөжийн харьцаа	Үр дүн
1. "тэг" хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Өөрчлөлт гарахгүй	Нэмэлт зардал гарахгүй	сөрөг
2. Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Өөрчлөлт гарахгүй	Нэмэлт зардал гарахгүй	сөрөг

3. Зах зээлийн механизм хэрэглэх, төрөөс зохицуулалт хийх	Өөрчлөлт гарахгүй	Нэмэлт зардал гарахгүй	сөрөг
4. Захиргааны шийдвэр гаргах	Өөрчлөлт гарахгүй	Өөрчлөгдөхгүй	сөрөг
5. Төрийн бус байгууллагаар төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Өөрчлөлт гарахгүй	Өөрчлөгдөхгүй	сөрөг
6. Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах	Хүрэх боломжтой	Нэмэлт зардал гарахгүй асуудлыг шийдвэрлэх боломжтой	зэрэг

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасан дараах 7 чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхэд сангийн мөнгийг зарцуулдаг. Үүнд:

1. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх
2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
3. Орчны эрүүл мэндийг хамгаалах
4. Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх
5. Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх
6. Эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах
7. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийг өөрчлөн найруулж хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчнийг Монгол Улсад эмчлэх технологийг нутагшуулах агуулга бүхий нэмэлт өөрчлөлтийг тус тус оруулж өөрчилнө. Дээрхи долоон арга хэмжээг санхүүжүүлж байсныг нэгтгэж, бүлэглэснээр арга хэмжээ тус бүрийн санхүүжилтийн хэмжээ нэмэгдэнэ.

Гадаад улсад эмчлүүлэх шаардлагатай байсан 39 өвчнийг 2018 онд 26 болгон бууруулсан. 2018-2023 онд дахин 4 өвчний эмчилгээг эмчилгээг нэвтрүүлэх, нутагшуулах замаар Монголд эмчлэгдэх боломжгүй өвчнийг үе шаттай бууруулахаар ажиллаж байна. Гэвч нэг шинэ технологийг нэвтрүүлж нутагшуулахад дан ганц техник, тоног төхөрөмж төдийгүй хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх хэрэгцээ шаардлага чухлаар тавигдаж байна.

Өнөөгийн байдлаар эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах зорилгоор гадаад улс оронд багаар (5 хүнтэй баг, 10 хоног) сургахад жилд дунджаар 300-400 сая төгрөг (сургалтын зардал орохгүйгээр), гадаадын эмнэлгийн мэргэжилтний баг (5 хүнтэй 10 хоног) авчирч ажиллуулахад дунджаар 100 сая төгрөг зарцуулж байгаа тооцоолол байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчнийг Монгол Улсад эмчлэх хүний

нөөцийн чадавхи сайжрахын зэрэгцээ иргэн оношилгоо, эмчилгээ хийлгэх зорилгоор гадаад улс орныг зорьж эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн дарамтад орох эрсдэл буурах ач холбогдолтой.

## **ЗУРГАА.ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Дэлхий нийтийн чиг хандлага нь өвдсөн хойно нь биш өвчнийг эрт илрүүлэх, эрт оношлох, нэгэнт өвдсөн үед хүндрэлээс сэргийлэх, эрүүл мэндээс үүдэлтэй иргэнд учрах санхүүгийн дарамтыг бууруулахад бүх бодлогоо, арга хэмжээг чиглүүлж байна. Дийлэнх улс орнууд архи, тамхины эсрэг хуулийг батлан хэрэгжүүлэхийн зэрэгцээ эдгээр бүтээгдэхүүнээс авсан татвараа эрүүл мэндийг дэмжих, нийгмийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээндээ зориулах эрх зүйн зохицуулалт ашигладаг. Тухайлбал, АНУ-ын ихэнх муж, Авсрали, Мексик, Чили, Дани, Финлянд, Норвеги, Франц, Их Британи, Ирланд, Носхон далайн арлын орнууд, БНСУ, Камбож, Өмнөд Африк зэрэг дэлхийн олон улсуудыг дурьдаж болно.

### **ДОЛОО. ЗӨВЛӨМЖ**

Дэвшүүлсэн зорилго, зорилтдоо хүрэхийн тулд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж батлан гаргах хувилбарыг сонгох замаар тулгамдсан асуудлыг шийдэх нь хамгийн үр дүнтэй гэж үзэж байна. Энэхүү хуулийн төслөөр дараах асуудлыг зохицуулах шаардлагатай байна:

1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан эх үүсвэрийн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтийг бүрэн хуваарилахгүй байгаа тул Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр 19.5 дахь заалтын “хөрөнгийг” гэсний дараа “төвлөрүүлэх,” гэж нэмэх,
2. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасан ерөнхий 7 чиглэлийг нэгтгэн хуулийн төсөлд 6 чиглэл болгон оновчтой тусгасныг хэрэгжүүлэх;
3. Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчнийг эмчлэх технологийг нутагшуулах, зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх талаар иргэдээс ирүүлсэн хүсэлтийг бүрэн шийдвэрлэдэг болох,
4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангаагүй эсхүл тэтгэмжийн шимтгэл төлж байгаагүй амьгүй донорт олгох оршуулгын тэтгэмж олгох асуудлыг шийдвэрлэдэг болох.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

### Хууль тогтоомж

1. Монгол Улсын үндсэн хууль
2. Эрүүл мэндийн тухай хууль
3. Хууль тогтоомжийн тухай хууль
4. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль

### Цахим эх сурвалж

<https://www.legalinfo.mn/law/details/11119>

<https://www.legalinfo.mn/law/details/11848>

### Монгол Улсын Засгийн газрын тогтоол

1. Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоол
2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн “Журам батлах тухай” 37 дугаар тогтоол
3. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Тогтоолын өөрчлөлтөд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 323 дугаар тогтоол

---ooOoo---

## ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын дагуу хийлээ.

### **Нэг. Хуулийн этгээдийн зардал**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хуулийн этгээдэд заавал биелүүлэх шинжтэй үүрэг хариуцлага тусгаагүй тул нэмэгдэл зардал үүсэхгүй.

### **Хоёр. Иргэний үүсэх зардал**

Уг хуулийн төслийг хэрэгжүүлэхэд иргэнд үүрэг хүлээлгэсэн зохицуулалт тусгаадаагүй тул иргэнд үүсэх зардал байхгүй болно.

### **Гурав. Төрийн байгууллагын зардал**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь хандив, тусламж, эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон эх үүсвэр, архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь, тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөс бүрдэнэ гэж заасан байдаг. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих санд татан төвлөрүүлэх орлогыг бүрэн татан төвлөрүүлж, Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад хуваарилж олговол нийгмийн эрүүл мэндийн төсөл, арга хэмжээнүүдийн төлөвлөгөө болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаагүй болон нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа нь Нийгмийн даатгалын тухай хуульд заасан хугацаанд хүрэхгүй байгаа амьгүй донорт олгох оршуулгын тэтгэмж олгоход шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх боломжтой талаар хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан. Архи, согтууруулах ундаа, тамхины онцгой албан татвар, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын орлогоос Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан хувиар тооцож үзэхэд 2023 онд 10 тэрбум төгрөгийг эрүүл мэндийг дэмжих санд хуваарилах боломжтой байна.

Тус 10 тэрбум төгрөгөөс урьдчилсан тооцооллоор нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгаа, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт санхүүжилтийн 60 хувийг, гадаад эмчилгээний зардалд 20 хувийг, эмчилгээ оношилгооны технологи нутагшуулахад 19.5 хүртлэх хувийг, амьгүй донорын оршуулгын зардалд 0,5 хувийг тус тус зарцуулахаар тооцоолов.

Иймээс Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хувьд төрийн байгууллагатай холбоотой нэмэгдэл зардал гарахгүй бөгөөд одоогийн хүний нөөц, төсвийн хүрээнд хэрэгжүүлэх бүрэн боломжтой.

Хүснэгт 1

№	Зардлын ангилал	Санхүүжилт (төгрөг)	Нийт санхүүжилтэд эзлэх хувь
1	Нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгаа, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх цогц арга хэмжээ	6 тэрбум	60
2	Гадаад эмчилгээний зардалд	2 тэрбум	20
3	Эмчилгээ оношилгооны технологи нутагшуулах	19,5 тэрбум	19,5
4	Амьгүй донорын оршуулгын зардалд	0,5 тэрбум	0,5
Нийт		10 тэрбум	

--- оОо ---

## Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд олон нийтээс санал авсан тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулгад олон нийтээс санал авахаар Эрүүл мэндийн яамны вэб сайтад 2023 оны 05 дугаар сарын 23-аас 06 дугаар сарын 23-ны хугацаанд байршуулан нээлттэй хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлгийн хугацаанд олон нийтээс санал ирээгүй болно.

Эрүүл мэндийн яамны вэб сайт:

[Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн дагуу олон нийтээс санал авч байна. \(moh.gov.mn\)](http://moh.gov.mn)

ЧМД БНСУ, БНХАУ-Д СУРАЛЦАНА | ЭМЯ ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨӨЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛБЭ | ЭМЯ ОРОН НУТАГТ НҮҮДНИЙ ЭРҮҮЛ МЭ

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ** ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ Тусламж

НҮҮР | ЯАМНЫ ТУХАЙ | ТӨРИЙН ҮЙЛЧИЛЭЭ | ЭРХ ЗҮЙ | МЭДЭЭ | ИЛ ТОД | ШИЛЭН ДАНС | СТАТИСТИК

### Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн дагуу олон нийтээс санал авч байна.

2023-05-23 12:05:00

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн дагуу олон нийтээс санал авч байна. Хуулийн төсөл, танилцуулгатай танилцан, саналаа Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газарт гэж хаяглан, албан бичгээр ирүүлнэ үү. 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн дотор ирүүлэхийг хүсье. Хуулийн төслийг энд дарж үзнэ үү

Жиргэх

#### Холбоотой мэдээ, мэдээлэл

- НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХТЭЙ ЦУСНЫ АЛБА ОЙН БАЯРАА ТЭМДЭГЛЭВ**
- ЭРТ ИЛРҮҮЛГИЙН БАГ БҮР НҮҮДЛИЙН АМБУЛАТОРИОР ҮЙЛЧИЛЖ БАЙНА**
- ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**ХУУЛИЙН АЖЛЫН ХЭСЭГ**

№	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар	
1	Пүрэв Оюунцэцэг	Эрүүл мэндийн яам Бодлого төлөвлөлтийн газрын дарга	99996434	
2	Дангаа Баярболд	Нийтийн эрүүл мэндийн газрын дарга	91113003	
3	Лхагважав Мөнхцэцэг	Санхүү, даатгалын хэлтсийн дарга	99031785	

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ЯАМДААС ИРҮҮЛСЭН  
САНАЛЫН ТОВЬЕОГ**

Д/д	Яамд	Ирүүлсэн албан бичгийн утга	Саналыг тусгасан байдал, тайлбар
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Тусгайлан өгөх саналгүй	
2	Барилга, хот байгуулалтын яам	Дэмжиж байна	
3	Батлан хамгаалах яам	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 19.3.4 дэх заалтын "эрүүл мэндийн тусламж ..." гэсний өмнө "өмчийн хэлбэр харгалзахгүй"	Одоогийн мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжилт авахаар материалаа ирүүлэх байгууллагад ямар нэгэн өмчийн хэлбэр зааж өгөөгүй, өмчийн бүх хэлбэрийн байгууллага материал ирүүлэх нь нээлттэй тул саналыг тусгаагүй.
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	Тусгайлан өгөх саналгүй	
5	Гадаад харилцааны яам	Дэмжиж байна	
6	Зам, тээврийн хөгжлийн яам	Тусгайлан өгөх саналгүй	
7	Сангийн яам	Дэмжиж байна	
8	Соёлын яам	Тусгайлан өгөх саналгүй	
9	Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яам	Тусгайлан өгөх саналгүй	
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Тусгайлан өгөх саналгүй	
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т "Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад хуулийн төсөл болон дагаж гарах хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрд дараах мэдээллийг агуулсан тайлбарыг тусгана" гэж заасны дагуу дээрх хуулийн төслийг өөрчлөн найруулах болсон шаардлагыг агуулсан тайлбар бүхий дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасны дагуу хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангах нь зүйтэй.	Саналыг хэрэгжүүлсэн.
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Дэмжиж байна	
13	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Тусгайлан өгөх саналгүй	

14	Эрчим хүчний яам	Тусгайлан өгөх саналгүй	
15	Эдийн засаг, хөгжлийн яам	Дэмжиж, тусгайлан өгөх саналгүй. Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасан бүрдэл материалыг хангаж ирүүлж байхыг анхаарна уу.	Саналыг хэрэгжүүлсэн.

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ